



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 04

Сүхбаатар

Өргөдөл хянан шалгасан тухай

Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын Газрын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан Г.Саранцэцэгийн “Ажлаас үндэслэлгүй халагдсан тухай” өргөдлийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”, аймгийн Засаг даргын 2017 оны А/275 захирамжаар томилогдсон өргөдлийг хянан шалгах ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгчийн 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Б/31 дүгээр “Ажлаас халах тухай” тушаалыг эрх зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

2.Захиргааны актыг үүссэн нөхцөл байдал, зөрчлийн хэмжээг зөв тодорхойлж, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж байхыг Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Эрдэнэбаатар/-д анхааруулсугай.

ДАРГА



Ө.СУВДАА